

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын

Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2026-05-08/

Ажлын хэсгийн 66 дугаар хуралдаан 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10 цагт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хурлын танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдаанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Авилгатай тэмцэх газрын ахлах ажилтан Р.Бямбасүрэн, Татварын Ерөнхий газрын байцаагч Ч.Сувдаа, Ашигт малтмал, газрын тосны газрын ахлах мэргэжилтэн С.Баттулга, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюунбилэг, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Б.Ринченпагма, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн ахлах нягтлан бодогч Ц.Болормаа, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хүний эрх, хөгжил төв ТББ-ийн тэргүүн Г.Уранцоож, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн С.Цэрэнпүрэв, Ангир нүдэн мөндөөхэй ТББ-ийн тэргүүн Я.Цэрэнханд, Ховдын толь ТББ-ийн тэргүүн Г.Төрмөнх, МБОИЗ-ын гишүүн М.Чинзориг, Г.Оюунтуяа нар болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон оролцов.

Хуралдааныг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Дашпүрэв нээж үг хэлэв.

Б.Дашпүрэв- Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улс ОУИТБС-ыг олон жил тогтвортой хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч, асуудлууд оршсоор байна. Тухайлбал, компаниуд идэвхтэй оролцохгүй байна. Хариу өгөхгүй үзэгдэл байсаар байна. Ноднингийн тайлан боловсруулсан байгууллага бас сайн ажиллахгүй байгаа нь ажиглагдсан. Хариу өгөөгүй байгууллагын араас асууж тодруулах ажлыг хийгээгүй дутагдал илэрсэн байна. 10-р сард болох Баталгаажуулалтад бэлтгэх төлөвлөгөөг өнөөдрийн хуралдаан дээр ярилцана. 2022 оны Баталгаажуулалтаар манай улс 70 оноо авсан явдлыг ахиулж, 80 оноо авах нь бидний зорилт гэж үзэж байна. Ингээд хурлаа эхлүүлье гээд хурлыг удирдан явуулав.

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжүүдийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Танилцуулгын дараа асуулт асууж, саналаа хэлэв.

Г. Уранцоож- За, баярлалаа. Ямар төрийн бус байгууллагууд орон нутагт, ялангуяа суманд ажиллаж байгаа талаар судалгаа хийх нь зүйтэй байна. Тэдний чадавхийг сайжруулах сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

С.Баттулга- Уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хүйсийн тооны мэдээллийг Уулын ажлын тайлангаас авч болно. Шаардлагатай гэж үзвэл бидэнд

хандаж болно. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу байгуулсан гэрээний тайлан мэдээг манай дээр гаргасан байгаа. 305 аж ахуйн нэгжээс 1264 тайланг авсан үүнийг "Гэрээний ил тод байдлын" веб сайтад оруулж болно.

Ч.Сувдаа- Кадастрын системд компанийн регистрийг оруулах хэрэгтэй байна. Тэгвэл хайх ажиллагаа нилээд амар болох юм.

С.Баттулга- Болох байх, судалж үзье.

Н.Баярсайхан- 33 зөвлөмжийг төрөлжүүлж, багцлаад төлөвлөгөө гаргах нь зөв юм байна. Олон ажил хийгдээгүй, хэрэгжээгүй байна. Яамны манлайлал, бодлогын дэмжлэг, санхүүгийн эх үүсвэр дутмагаас шалтгаалсан гэж бодож байна. Удирдлагууд байнга өөрчлөгдөж байгаа нь ажилд муугаар нөлөөлж байна. Иймд дорвитой, эрс ахиц гаргах хэмжээний төлөвлөлт, арга хэмжээ авах нь зүйтэй байна. Ер нь манай яамд, агентлагууд ямар төлөвлөгөөтэй байна. АМГ, УБЕГ, БОУАӨЯ-аас төлөөллийг үр нөлөөтэй оролцуулж салбар хоорондын уялдааг хангах хэрэгтэй байна.

Б. Дашпүрэв- Зарим зүйлийг тодруулж өгөх хэрэгтэй байна. Төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа. Хийгдэх ажлуудын хугацаануудыг шахаж, тодорхой болгох хэрэгтэй байна. Хугацаанууд хэтэрхий хойшоо байгааг залруулах хэрэгтэй байна. Зарим мэдээллүүд, тухайлбал, 25,18-д дээр байгаа мэдээлэл төрийн байгууллага дээр бэлэн байгаа тул тэдгээрийг авахад асуудал байхгүй. Геологийн алба, АМГТГ-ын хооронд системийн шинэчлэл хийж байгаа ирэх долоо хоногт дуусах байх. Орон нутагтай хамтран ажиллах шаардлагатай байгаа бөгөөд боломжийн хирээр төсвийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа. АҮЭБЯ санаачилгыг бүрэн дэмжиж байгаад итгэж болно. Мөн Ерөнхий сайд хуулийн төслийг сайн дэмжиж байгаа учир хууль явах байх гэсэн найдлагатай байна.

С.Цэрэнпүрэв- 25.31- д дурдсан асуудлаар Сангийн яамнаас сургалт зохион байгуулж байсан. Энэ чиглэлээр мэдээлэл авч болно.

Г.Оюунтуяа- Ажлын алба боломжийн ажиллаж байна. Санхүүжилтгүйгээс бүсчилсэн сургалт зэрэг олон ажил хийгдэхгүй байна. Дэд хэсэг байгуулах гэж байгааг дэмжиж байна. Түүнд орох хүний нэрийг өгье. Мөн "Уул уурхайн долоо хоног" зэрэг олон нийтийн арга хэмжээнд оролцож боломжийг ашиглах хэрэгтэй байна. Аж ахуйн нэгж дээр байгаа мэдээллийг авдаг байх нь илүү зохистой гэж бодож байна. Томоохон компаниуд өөрийн тайлангаа веб сайт дээрээ тавих нь зөв байна. Энэ төлөвлөгөөний төсөлд тусгасан ажлуудын талаар Ажлын албанаас илүү Яамнаас Яамруу бичиг явуулах нь илүү оновчтой гэж байна.

Я.Цэрэнханд- 25.6-д дурдсан асуудлыг хуулийн төсөлд оруулах саналтай байна. 25.14- дээр яригдсан асуудлын хувьд хуулиар хориглосон газар дээр олгогдсон тусгай зөвшөөрлийн мэдээлэл харагдахгүй байгаа учир энэ мэдээллийг оруулья. Энэ чиглэлээр байнга л шүүх дээр маргаан явж ирсэн бөгөөд үүнийг таслан зогсоох хэрэгтэй байна. Авилгын асуудлыг хэрхэн тусгах талаар заалт оруулах хэрэгтэй

байна. Ажлын хэсгийн хуралдааны ирцийг сайжруулах талаар холбогдох талуудад албан тоот явуулах нь зүйтэй байна.

Г.Төрмөнх- Зардлыг төлөвлөгөөнд оруулах тухай зөвлөмж өгсний дагуу зардлыг оруулахдаа эх үүсвэрийг оруулж өгөх хэрэгтэй гэж бодож байна. Ер нь бол улсын төсвөөс зардлын эх үүсвэр гарах боломжтой гэж үзэж байна. 25.2-д заасан зүйлийг онгорхой хаясан нь оновчгүй гэж үзэж байна. Энэ заалтын дагуу ажил хийх ёстой шүү. Үүнийг хаана хаанаа анхаарах хэрэгтэй байна. 25.5-д заасан заалтыг хуулиар зохицуулна гэснийг больж, харин даруй хийлгэх хэрэгтэй гэж бодож байна. ИНБ-ын саналуудаа тусгах, иргэдэд ил тод болгох мэдээллийн жагсаалтыг бий болгох, авилгын асуудлаар тодорхой ямар алхам хийх, гэрээ, тээврийн болон туслан гүйцэтгэгч нарын мэдээллийг 1 платформ дээр байршуулах зэргээр дорвитой алхам хийх хэрэгтэй байна.

Ч.Сувдаа- Бидний зүгээс хамтран ажиллах бүрэн боломжтой. Экспортын гэрээний бүртгэлтэй болсон байгаа. Мөн Ашигт малтмалын биржийн тодорхой мэдээллийг авч байгаа. Тээврийн гэрээний бүртгэлийг мөн авч байгаа. Иймд эдгээр чиглэлүүдээр мэдээлэл авч болно.

Ц.Болормаа- Жил болгон тайлан хийдэг. Нэгэнт авсан тайлангуудаа нэгтгэл хийх ажлаа өөрсдөө хийх хэрэгтэй байна. Ялангуяа энд 2 яам ч оролцож байгаа. Мэдээлэлд ойрхон хүмүүст мэдээлэл ил тод байдаг, харин иргэдэд ил тод биш байна. Манай компанийн хувьд ажиллахад тун хэцүү байгаа. Энэ нь хөрөнгө оруулагчийг ихэнхдээ үргээж байна. Засгийн газар гэрээ байгуулсан ч иргэдэд ойлгуулах ажлаа хийхгүй байна. Янз бүрийн шалгалт их ирж байна. Иргэд нь шүүмжлээд ажил хийхэд үнэхээр хэцүү байгааг зогсоох хэрэгтэй байна.

Н.Баярсайхан- 10-р сард болох Баталгаажуулалтад бэлтгэх төлөвлөгөө хэлэлцэж байна. Хамгийн түрүүнд бид бэлтгэл хангах, асуудлаа ойлгохын тулд өөрийн үнэлгээ хийх хэрэгтэй байна. Өмнө нь 2 ч удаа өөрийн үнэлгээ хийж байсан туршлагатай. Үүнд зориулаад ажлын дэд хэсэг байгуулах саналтай байна. ҮЗ, АХ-ийн гишүүддээ 2023 оны стандартын талаар мэдлэгийг өгөх хэрэгтэй байна. Мөн эдгээр 33 зөвлөмжүүдийн талаар ойлголт өгөх хэрэгтэй байна. Ялангуяа 2023 оны шинэ стандарт шаардлагын агуулгыг бид өөрсдөө ойлгож байж бид үнэлгээгээ зөв өгч чадна. Баталгаажуулалтын үнэлгээнд бид өөрсдөө голлон орно, тийм учраас мэдлэгтэй байх хэрэгтэй. ОУИТБС түүний шаардлага, зарчмыг мөн Авилгын асуудал, мэдээллийн ил тод байдлыг ойлгуулах, хэрэгжүүлэх арга зүй, арга хэмжээ нь аймаг, сумын болон үндэсний түвшинд өөр өөр ялгаатай байх хэрэгтэй юм байна. Манай байгууллага Австрали дахь Трансдаренси Интэрнэшнл байгууллагын тэтгэлгээр 2023 оны шинэ стандартын хэрэгжилтийг ахиулах дэмжлэг болох тэтгэлэгт төсөл хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд ҮЗ болон ОТОАХ, орон нутгийн удирдах ажилтанууд, олон нийтийн хүрээнд судалгаа хийж үзэхэд 2023 оны шинэ стандарт шаардлагын талаар мэдлэг ойлголт тун тааруу байгаа нь санаа зовоож байна. Иймд, 7.1-р шаардлагын агуулгаар 2008 онд анх Өвөрхангай аймагт "ОУИТБС- Орон нутгаас эхлэнэ" олон талт хэлэлцүүлэг хийж байсан, түүнээс хойш ТАН эвсэл олон аймаг

суманд зохион байгуулж сургамж туршлага хуримтлуулсан. Энэ туршлагадаа сууриалаад дээрх тэтгэлгийн хүрээнд 2023 оны шинэ стандарт шаардлагын яг уул уурхай бүхий сумдын түвшинд хамгийн их хамаарал бүхий, талуудын зөрчлийг бууруулахад хувь нэмэр оруулах хамтын ажиллагааны гэрээний ил тод байдал (2.4). орон нутагт шууд төвлөрдөг орлогын ил тод байдал, төвлөрсөн төсвөөс орон нутагт дахин хуваариладаг төсөв түүнийг зарцуулалтын ил тод байдал, байгаль, орчин нийгмийн нөлөөллийн эрсдлийг бууруулах зардлын ил тод байдал гэсэн шаардлагуудыг орон нутгийн түвшинд оролцогч талууд нэг зааланд цугларч, талууд нүүр нүүрээ харж ярилцах "Нутгийн яриа: Орон нутгийн хэлэлцүүлэг" удирдамж боловсруулж байна. Энэ удирдамжид Татвар, АТГ бүгд тал талаасаа саналаа өгч боловсруулж дуусгах, удирдамжийг АҮЭБЯ маань дэмжиж өгнө үү. Мөн ОҮИТБС-ыг 20 гаруй жил хэрэгжүүлэх явцад өгсөн зөвлөмжүүдийн биелэлтийг УИХ-д энэ 5, 6-р сард танилцуулах хэрэгтэй байна. Эдгээр ажлыг Төлөвлөгөөнд оруулж өгнө үү.

М.Чинзориг- Танилцуулсан төлөвлөгөөг дэмжиж байна. Гол нь хуулиа батлуулах, иргэдэд нээлттэй байх, эцсийн өмчлөгчийг ил тод болгох дорвитой арга хэмжээ авах, гадагшаа сурталчилах талаар сурталчилгаа хүргэх чиглэлээр идэвхтэй ажиллах хэрэгтэй байна.

Б. Дашпүрэв- Гадагшаа сурталчилгаа хүргэх талаар ажиллах хэрэгтэй байна. Энэ талаар нэмж ажил оруулж, төлөвлөгөөндөө тусгая. Шаардлагатай зардлыг тооцож, оруулья. Хариуцах тал, хэрэгжүүлэх хугацааг маш тодорхой нарийвчлан оруулан оруулья. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой бичгийг явуулах, мөн хуралд оролцож байх талаар албан тоотуудыг явуулья. Төлөвлөгөөний дагуу дэд хэсгийг даруй байгуулж, ажиллуулах шаардлагатай байна. Авилгаас сэргийлэх дотоод дүрмийг компанийн соёлд нэвтрүүлэх зорилгоор мөн компаниудад албан тоотуудыг явуулах арга хэмжээ авья. Хууль хүлээлгүйгээр чадах юм юу байх гэдэг талаар ажиллах хэрэгтэй байна. Ажлын дэд хэсгээ байгуулах, нэрсээ 5-р сарын 13-ны дотор Ажлын албанд ирүүлэх хэрэгтэй байна.

Хуралдааны шийдвэрийг танилцуулж, гишүүд дэмжсэнээр хуралдаан өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга

Б.Дашпүрэв

АҮЭБЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Т.Амартүвшин

Тэмдэглэлийг хянасан:

ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын ажлын албаны санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг